

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БШУ	Боловсрол Шинжлэх Ухаан
ТӨБЗГ	Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газар
НДШ	Нийгмийн Даатгалын Шимтгэл
ТЕЗ	Төсвийн Ерөнхийлөн Захирагч

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
/төгрөгөөр/ .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
/Төгрөгөөр/.....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
/Төгрөгөөр/.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /Төгрөгөөр/.....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	13
3.Аудитын тайлан.....	14
3.1. Ерөнхий зүйл.....	14
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй .....	14
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт .....	14
3.4. Материаллаг байдал .....	15
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	15
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....	16
3.7. Шилэн дансны мэдээлэл .....	17
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	18
3.9. Аудитын илрүүлэлт.....	18
Залруулсан алдаа.....	18
Аудитын зөвлөмж.....	19
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд .....	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	22



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ШИНЭ  
ЭРИН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ  
Б.АМАРТҮВШИН ТАНАА

2021.02.25 № 07/482  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Аудитын санал, дүгнэлт

### Зөрчилгүй санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ерөнхий боловсролын Шинэ эрин сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ерөнхий боловсролын Шинэ эрин сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Нийслэлийн ерөнхий боловсролын Шинэ эрин сургууль нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд үндсэн 4 бүлгийн 21 зорилт арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 100 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Аудитын хүрээнд бусад асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа тусдаа дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

## **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

**АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР**



**Ц.НАРАНЧИМЭГ**

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>70,434,572.83</b>	<b>101,723,963.64</b>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	-
3121	Төгрөг	-	-
33	АВЛАГА	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	70,434,572.83	101,723,963.64
351	Түүхий эд материал	45,045,591.83	66,160,962.64
35110	Тусгай зориулалттай материал	45,045,591.83	66,160,962.64
354	Хангамжийн материал	25,388,981.00	35,563,001.00
35410	Бичиг хэргийн материал	2,527,238.00	7,174,423.00
35420	Аж ахуйн материал	17,990,149.00	22,065,660.00
35440	Түлш, шатах тослох материал	-	987,480.00
35470	Бусад хангамжийн материал	4,871,594.00	5,335,438.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3,931,146,708.16</b>	<b>3,906,554,059.82</b>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,931,146,708.16	3,906,554,059.82
392	Биет хөрөнгө	3,928,493,457.81	3,892,335,023.23
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,750,560,295.00	3,750,560,295.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(66,974,291.04)	(133,948,582.08)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	60,800,000.00	20,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(60,800,000.00)	-
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	173,901,950.79	88,461,917.79
39206	Хуримтлагдсан элэгдэл	(140,207,112.02)	(49,419,451.06)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	481,125,408.06	417,929,719.86
39208	Хуримтлагдсан элэгдэл	(345,700,204.25)	(280,851,127.87)
39214	Бусад үндсэн хөрөнгө	4,744,680.00	4,744,680.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(163,609.68)	(327,219.36)
39217	Ном	71,206,340.95	75,184,790.95
393	Биет бус хөрөнгө	2,653,250.35	14,219,036.59
39301	Програм хангамж	48,767,381.74	23,326,829.80
39302	Хуримтлагдсан элэгдэл	(46,114,131.39)	(9,107,793.21)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>4,001,581,280.99</b>	<b>4,008,278,023.46</b>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,218,637.76	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,218,637.76	-
413	Өглөг	2,218,637.76	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	272,436.49	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,946,201.27	-
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,999,362,643.23	4,008,278,023.46
51	Засгийн газрын хувь оролцоо	3,999,362,643.23	4,008,278,023.46
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,132,187,517.32	3,132,187,517.32
51101	Өмч: - төрийн	3,132,187,517.32	3,132,187,517.32
512	Хуримтлагдсан үр дүн	(1,017,224,683.58)	(1,008,309,303.35)
51210	Өмнөх үеийн үр дүн	(1,017,224,683.58)	(1,017,224,683.58)
51220	Тайлант үеийн үр дүн	-	8,915,380.23
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,884,399,809.49	1,884,399,809.49
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>4,001,581,280.99</b>	<b>4,008,278,023.46</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,082,174,074.00</b>	<b>1,299,959,932.30</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>47,113,174.00</b>	<b>83,142,132.30</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	37,877,306.00	83,142,132.30
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	37,877,306.00	83,142,132.30
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	37,877,306.00	83,142,132.30
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	9,235,868.00	-
122001	Хандив тусламж /дотоод/	9,235,868.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,035,060,900.00</b>	<b>1,216,817,800.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,003,735,400.00	1,190,617,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,003,735,400.00	1,190,617,800.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	31,325,500.00	26,200,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	31,325,500.00	26,200,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,166,860,544.92</b>	<b>1,291,044,552.07</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,166,860,544.92</b>	<b>1,291,044,552.07</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,156,992,363.67	1,253,899,253.95
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	794,055,702.45	906,199,026.36
210101	Үндсэн цалин	794,055,702.45	906,199,026.36
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	99,608,585.00	113,632,411.53
210201	Тэтгэврийн даатгал	67,694,437.44	78,014,280.00
210202	Тэтгэмжийн даатгал	8,668,293.73	9,178,151.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,343,417.34	7,261,882.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,555,284.32	1,736,388.00
210205	Эрүүл мэндийн даатгал	15,347,152.18	17,441,710.53
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	47,758,092.27	38,196,627.23
210301	Гэрэл, цахилгаан	25,619,742.99	16,125,132.73
210302	Түлш, халаалт	17,343,926.32	18,633,488.50
210303	Цэвэр, бохир ус	4,794,422.96	3,438,006.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	27,714,604.42	22,504,054.00
210401	Бичиг хэрэг	3,743,878.00	4,552,035.00
210402	Тээвэр, шатахуун	2,949,894.40	1,512,520.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,629,099.04	8,115,302.00
210404	Ном, хэвлэл	256,000.00	197,495.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	600,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,535,732.98	8,126,702.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	-	731,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	731,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	7,747,485.00	10,789,480.00
210604	Урсгал засвар	7,747,485.00	10,789,480.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	39,641,044.00	28,937,726.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	34,360,395.00	25,907,926.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	127,400.00	131,900.00

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	30,000.00	30,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,123,249.00	867,900.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>140,466,850.53</b>	<b>132,908,928.83</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	17,958,395.61	11,314,148.19
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	122,508,454.92	121,594,780.64
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>9,868,181.25</b>	<b>37,145,298.12</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>8,885,000.00</b>	<b>820,000.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	7,885,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	820,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>983,181.25</b>	<b>36,325,298.12</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	983,181.25	36,325,298.12
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(84,686,470.92)</b>	<b>8,915,380.23</b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	-	-
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	47,172,989.50	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	9,295,683.50	-
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	37,877,306.00	-
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>(47,172,989.50)</b>	<b>-</b>
<b>5</b>	<b>НИИТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(131,859,460.42)</b>	<b>8,915,380.23</b>



### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх он	Тайлант он
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,035,060,900.00</b>	<b>1,216,817,800.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,035,060,900.00</b>	<b>1,216,817,800.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,003,735,400.00	1,190,617,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,003,735,400.00	1,190,617,800.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	31,325,500.00	26,200,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	31,325,500.00	26,200,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,035,060,900.00</b>	<b>1,202,957,800.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,035,060,900.00</b>	<b>1,202,957,800.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,025,192,718.75</b>	<b>1,165,812,501.88</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	793,742,764.33	906,199,026.36
210101	Үндсэн цалин	417,040,800.00	460,811,395.30
210102	Нэмэгдэл	242,409,107.33	328,901,857.46
210103	Унаа хоолны хөнгөлөлт	40,164,040.00	33,059,813.99
210104	Урамшуулал	94,128,817.00	83,425,959.61
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	99,369,399.46	113,904,848.02
210201	Тэтгэврийн даатгал	66,143,417.33	77,374,694.29
210202	Тэтгэмжийн даатгал	9,282,727.13	9,210,836.21
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,384,948.00	5,840,015.48
210204	Ажилгүйдлийн даатгал	1,596,137.00	3,264,890.34
210205	Эрүүл мэндийн даатгал	15,962,170.00	18,214,411.70
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	46,937,900.00	40,142,828.50
210301	Гэрэл, цахилгаан	24,799,550.72	18,071,334.00
210302	Түлш, халаалт	17,343,926.32	18,633,488.50
210303	Цэвэр, бохир ус	4,794,422.96	3,438,006.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	18,637,964.04	31,235,224.00
210401	Бичиг хэрэг	4,350,050.00	8,779,220.00
210402	Тээвэр, шатахуун	3,090,450.00	2,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,578,199.04	8,115,302.00
210404	Ном, хэвлэл	358,860.00	197,495.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,260,405.00	11,643,207.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	265,000.00	771,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	265,000.00	771,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	5,100,600.00	11,087,980.00
210604	Урсгал засвар	5,100,600.00	11,087,980.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	41,243,595.00	28,937,726.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	35,629,395.00	25,907,926.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	127,400.00	131,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	30,000.00	30,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,456,800.00	867,900.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	19,895,495.92	33,533,869.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	19,895,495.92	33,533,869.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>9,868,181.25</b>	<b>37,145,298.12</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	8,885,000.00	820,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	7,885,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	820,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	983,181.25	36,325,298.12
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	983,181.25	36,325,298.12

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	=	<u>13,860,000.00</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	13,860,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	13,860,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	13,860,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	13,860,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	=	<u>(13,860,000.00)</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

**/Төгрөгөөр/**

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	3,132,187,517.32	1,884,399,809.49	(885,365,006.97)	4,131,222,319.84
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>3,132,187,517.32</b>	<b>1,884,399,809.49</b>	<b>(885,365,006.97)</b>	4,131,222,319.84
Тайлант үеийн үр дүн	-	-	(131,859,676.61)	(131,859,676.61)
<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>3,132,187,517.32</b>	<b>1,884,399,809.49</b>	<b>(1,017,224,683.58)</b>	3,999,362,643.23
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>3,132,187,517.32</b>	<b>1,884,399,809.49</b>	<b>(1,017,224,683.58)</b>	3,999,362,643.23
Тайлант үеийн үр дүн	-	-	8,915,380.23	8,915,380.23
<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>3,132,187,517.32</b>	<b>1,884,399,809.49</b>	<b>(1,008,309,303.35)</b>	4,008,278,023.46

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Лөгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,190,617,800.00	1,154,359,966.88	36,257,833.12	97.0
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,190,617,800.00	1,154,359,966.88	36,257,833.12	97.0
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,189,797,800.00	1,153,539,966.88	36,257,833.12	97.0
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	917,944,200.00	906,199,026.36	11,745,173.64	98.7
Үндсэн цалин	462,702,800.00	460,811,395.30	1,891,404.70	99.6
Нэмэгдэл	328,430,600.00	328,901,857.46	(471,257.46)	100.1
Унаа хоолны хөнгөлөлт	40,810,000.00	33,059,813.99	7,750,186.01	81.0
Урамшуулал	86,000,800.00	83,425,959.61	2,574,840.39	97.0
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	114,743,100.00	113,904,848.02	838,251.98	99.3
Тэтгэврийн даатгал	78,025,300.00	77,374,694.29	650,605.71	99.2
Тэтгэмжийн даатгал	9,179,400.00	9,210,836.21	(31,436.21)	100.3
ҮОМШӨ-ний даатгал	7,343,600.00	5,840,015.48	1,503,584.52	79.5
Ажилгүйдлийн даатгал	1,835,900.00	3,264,890.34	(1,428,990.34)	177.8
Эрүүл мэндийн даатгал	18,358,900.00	18,214,411.70	144,488.30	99.2
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	44,438,900.00	40,142,828.50	4,296,071.50	90.3
Гэрэл, цахилгаан	17,697,500.00	18,071,334.00	(373,834.00)	102.1
Түлш, халаалт	23,351,700.00	18,633,488.50	4,718,211.50	79.8
Цэвэр, бохир ус	3,389,700.00	3,438,006.00	(48,306.00)	101.4
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	30,251,800.00	22,212,614.00	8,039,186.00	73.4
Бичиг хэрэг	5,871,100.00	4,524,820.00	1,346,280.00	77.1
Тээвэр, шатахуун	4,088,400.00	2,500,000.00	1,588,400.00	61.1
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	13,150,000.00	8,115,302.00	5,034,698.00	61.7
Ном, хэвлэл	231,400.00	197,495.00	33,905.00	85.3
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,910,900.00	6,874,997.00	35,903.00	99.5
<b>Нормативт зардал</b>	771,000.00	771,000.00	-	100.0
Нормын хувцас, зөөлөн эдлэл	771,000.00	771,000.00	-	100.0
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	21,102,700.00	11,087,980.00	10,014,720.00	52.5
Урсгал засвар	21,102,700.00	11,087,980.00	10,014,720.00	52.5
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	26,986,100.00	25,687,801.00	1,298,299.00	95.2
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,069,400.00	8,798,001.00	1,271,399.00	87.4
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00	-	100.0
Тээврийн хэрэгслийн татвар	131,900.00	131,900.00	-	100.0
Тээврийн хэрэгслийн оношлогоо	54,800.00	30,000.00	24,800.00	54.7
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	14,730,000.00	14,727,900.00	2,100.00	100.0
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	33,560,000.00	33,533,869.00	26,131.00	99.9
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	33,560,000.00	33,533,869.00	26,131.00	99.9
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	820,000.00	820,000.00	-	100.0
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	820,000.00	820,000.00	-	100.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	820,000.00	820,000.00	-	100.0
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,190,617,800.00	1,190,617,800.00	-	100.0
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,190,617,800.00	1,190,617,800.00	-	100.0
Улсын төсвөөс санхүүжих	1,190,617,800.00	1,190,617,800.00	-	100.0
<b>Төсвийн тохируулга</b>	-	-	-	-
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-	-	-

<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	-	-	-	-
<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1	1	-	100.0
Төсвийн байгууллага	1	1	-	100.0
<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	53	53	-	100.0
Удирдах ажилтан	1	1	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	40	40	-	100.0
Үйлчлэх ажилтан	12	12	-	100.0
Гэрээт ажилтан	-	-	-	-
<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	412	412	-	100
<b>ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД</b>	412	412	-	100
Төрийн өмчит ЕБС	412	412	-	100
Хувийн ЕБС	-	-	-	-
<b>СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА</b>	-	-	-	-
Төрийн өмчит СӨБ байгууллага	-	-	-	-
Хувийн өмчит СӨБ байгууллага	-	-	-	-

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

ЛӨГРӨГӨӨР/

Үзүүлэлт	Төлөвлөгө	Гүйцэтгэл
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	-
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	26,200,000.00	26,200,000.00
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	26,200,000.00	26,200,000.00
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	26,200,000.00	26,200,000.00
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	9,022,610.00	9,022,610.00
Бичиг хэрэг	4,254,400.00	4,254,400.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,768,210.00	4,768,210.00
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	17,109,925.00	17,109,925.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17,109,925.00	17,109,925.00
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	67,465.00	67,465.00
<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	67,465.00	67,465.00
Төвлөрүүлэх шилжүүлэг	67,465.00	67,465.00
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	26,200,000.00	26,200,000.00
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	26,200,000.00	26,200,000.00
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	-
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-

### **3.Аудитын тайлан**

#### **3.1. Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Ерөнхий боловсролын Шинэ эрин сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг захирал Б.Амартүвшин танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилт, цалин,нэмэгдэл хөлс олголт,худалдан авалтын анхан шатны баримтын бүрдэл,газар эзэмшлийн эрх, эд хөрөнгийн тооллого тооцоог явуулах зэрэгт мөрдөгдөх хууль, тогтоол, журам, заавруудыг мөрдөж ажиллах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 06-наас 2021 оны 02 дугаар сарын 25–ны хооронд Үндэсний аудитын газрын ахлах аудитор Б.Сэржмядаг, Баян ташаагийн эх Аудит ХХК-ийн аудитор Т.Хоролсүрэн, Д.Түмэндэмбэрэл ,Ч.Чимгээ нар хариуцаж хэрэгжүүлэв.

Ерөнхий боловсролын Шинэ эрин сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баян ташаагийн эх Аудит ХХК-д 2021 оны 01 сарын 22-ны өдрийн 02/01 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй**

Ерөнхий боловсролын Шинэ Эрин сургууль нь олон улсын түвшинд өрсөлдөх чадвартай, боловсролтой монгол хүүхдийг төлөвшүүлнэ гэсэн эрхэм зорилгынхоо хүрээнд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Монгол улсын хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэх
- Олон улсын хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэх
- Судалгаа шинжилгээ, туршилтын ажил хийх

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

#### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт**

Ерөнхий боловсролын Шинэ эрин сургуулийн 2020 оны санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэхийг судалж үзэхэд тус байгууллага нь Боловсрол, шинжлэх ухааны сайдын асуудлын хүрээний байгууллагуудад мөрдөгдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байна.

Боловсрол шинжлэх ухааны яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар тайлант онд сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Ерөнхий боловсролын Шинэ эрин сургуулийндотоод хяналтыг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны эхний хагас жилийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт үйл ажиллагааны зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2- хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд завсрын аудит хийгдээгүй материаллаг байдлын түвшинг 2020 оны эхний хагас жилийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт үйл ажиллагааны зардал 671,164.3 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 13,423.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажуулсан.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт үйл ажиллагааны зардал 1,291,044.5 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 25,820.9 мянган төгрөгөөр тооцож материаллаг байдлыг өөрчилж тодорхойлсон.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Ерөнхий боловсролын Шинэ эрин сургуулийн 2020 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6,696.7 мянган төгрөгөөр буюу 0.16 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгө, өр төлбөр буурч, бараа материал, цэвэр хөрөнгийн өмчийн данс өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	70,434.6	101,724.0	31,289.4
Үндсэн хөрөнгө	3,931,146.7	3,906,554.1	(24,592.6)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>4,001,581.3</b>	<b>4,008,278.0</b>	<b>6,696.7</b>
Өр төлбөр	2,218.6	0.0	(2,218.6)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3,132,187.5	3,132,187.5	0.0
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>4,001,581.3</b>	<b>4,008,278.0</b>	<b>6,696.7</b>

Бараа материалын дансны үлдэгдэл 101,724.0 мянган төгрөг болж 31,289.4 мянган төгрөгөөр өссөн байгаа нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 62,326.8 мянган төгрөгийн материал бэлтгэж, 29,304.6 мянган төгрөгийн материал зарцуулж, 1,732.8 мянган төгрөгийн материалыг өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлын 02 тоот шийдвэрээр акталж данснаас хассан байна. Бараа материалын өсөлтөд цар тахлын үед цахим сургалтын үйл ажиллагааг тасралтгүй явуулахад шаардлагатай хичээлийн хэрэглэгдэхүүнийг бэлтгэсэн нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,906,554.1 мянган төгрөг болж 24,592.6 мянган төгрөгөөр буурсан нь ТӨБЗГ-ын 2020 оны А-1/2077 дугаар тогтоолын дагуу ашиглалтын хугацаа дуусаж цаашид ашиглах боломжгүй болсон нийт 112,417.6 мянган төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хассан, 598 дугаар тогтоолоор 195,482.3 мянган төгрөгийн



анхны өртөгтэй, ашиглалтын хугацаа дууссан боловч цаашид ашиглах боломжтой хөрөнгийг 76,029.7 мянган төгрөгөөр дахин үнэлж ашиглах хугацааг шинэчлэн тогтоосноос шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалтаар 13,860.0 мянган төгрөгийн биет бус хөрөнгө, үнэ төлбөргүй хүлээн авсан 3,133.9 мянган төгрөгийн тавилга хэрэгсэл, 3,978.4 мянган төгрөгийн түрээсийн сурах бичгээр тус тус нэмэгдсэн байна.

Өр төлбөр дансны эхний үлдэгдэл ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл болох 272.4 мянган, гэрэл цахилгааны өглөг болох 1,946.2 мянган нийт 2,218.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсныг тайлант хугацаанд барагдуулан жилийн эцэст өр төлбөрийн үлдэгдэлгүй байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны нийт үлдэгдэл тайлант үеийн үр дүн 8,915.4 мянган төгрөг нэмэгдэж 4,008,278.0 мянган төгрөгөөр илэрхийлэгдсэн байна.

Ерөнхий боловсролын Шинэ эрин сургуулийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 217,785.9 мянган төгрөгөөр буюу 20.1 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлого 186,882.4 мянга, хөрөнгө дахин үнэлж үнэ төлбөргүй хүлээн зөвшөөрсөн орлого 76,029.7 мянга, дээд шатны байгууллагаас үнэ төлбөргүй хүлээн авсан ширээ сандал 3,134.0 мянга, үнэ төлбөргүй шилжүүлэн авсан нөөцийн ном 3,978.5 мянган төгрөгөөр өсөж, туслах үйл ажиллагааны орлого 5,125.5 мянга, хандив тусламжийн орлого 9,235.9 мянга, үнэ төлбөргүй орлого 37,877.3 мянган төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

Нийт зардал өмнөх оноос 124,184.0 мянган төгрөгөөр буюу 10.6 хувиар өссөн нь цалин, нэмэгдэл, НДШ 126,167.1 мянга, норматив зардал 731.0 мянга, эд хогшил, урсгал засварын зардал 3,041.9 мянга, урсгал шилжүүлэг 27,277.1 мянган төгрөгөөр өсөж, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 9,561.5 мянга, хангамж, бараа материалын зардал 5,210.6 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ, төлбөр хураамжийн зардал 10,703.3 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 7,557.9 мянган төгрөгөөр буурч 36,325.2 мянган төгрөгийн дутуу зарцуулалтыг буцаан төвлүүлсэн байна.

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,281,074.9 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,281,074.9 мянган төгрөгөөр тоцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 90,457.1 мянгаар бууруулж 1,190,617.8 мянган төгрөгөөр баталсан байна. Тус байгууллага нь багш ажилчдыг тоог нэмэх санал оруулсан төсвийг хасаж цалин, нийгмийн даатгалын зардал 90,457.1 мянган төгрөгөөр бууруулж баталсан байна. Өмнөх оны төсөвтэй харьцуулахад шуудан холбоо интернэтийн зардал 17,421.8 мянган, хичээл үйлдвэрлэл дадлага хийх зардал 15,105.0 мянган, урсгал засварын зардал 13,785.4 мянган төгрөгөөр өсөж батлагдсан байна.

#### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант оны төсвийн гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,190,617.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 1,154,359.9 мянган төгрөгийг зарцуулж 36,257.8 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,154,359.9 мянган төгрөг буюу 97 хувьтай байгаа нь цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 12,583.4 мянган, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 4.296.0 мянган, хангамж, бараа материалын зардлыг 8,039.2 мянган, эд хогшил, урсгал засварын зардлыг 10,014.7 мянган, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 1,271.4 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь Ерөнхий боловсрол хөтөлбөрийн үндсэн үйл ажиллагаа арга хэмжээ 36,257.8 мянган төгрөгөөр дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	71802	Ерөнхий боловсрол	1,190,617.8	1,154,359.9	(36,257.8)	97.0
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	1,189,797.8	1,153,539.9	(36,257.8)	97.0
1.2	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	820.0	820.0	0.00	100

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

2020 оны элсэлтийн шалгалтад 1048 хүүхэд бүртгүүлж нийт 26,200.0 мянган төгрөгийн хураамжийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ төлбөр, хураамжийн зардалд 17,109.9 мянга, хангамж, бараа материалын зардалд 9,022.6 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 67.5 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны мэдээлэлд оруулбал зохих 173 мэдээллээс хугацаандаа оруулсан 167 мэдээлэл, хугацаа хоцроосон 5 мэдээлэл байршуулж, 1 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

Шилэн дансны хуулийн дагуу байршуулах мэдээллээс аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан 1, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө 1, тушаал шийдвэр 3, нийт 5 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Мөн 12 дугаар сард 5,000.0 мянган төгрөгийн нэг гүйлгээг мэдээлээгүй байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар цалин хөлс илүү олгосон 4,664.4 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, санхүүгийн тайлангийн зөрүү 526.0 мянган төгрөгийн зөвлөмж, санхүүгийн тайлангийн тайлбар тодруулга дутуу ирүүлсэн байдалд өгсөн зөвлөмжүүдийг биелүүлж, орлогын төлөвлөгөө батлуулах, сургуулийн газрыг эзэмших гэрчилгээ бичиг баримттай болгох 30,875.5 мянган төгрөгийн зөвлөмжийн хэрэгжилт 66.6 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган.төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	4,664.4	2	4,664.4	-	-	-
Зөвлөмж	4	31,401.5	2	31,401.5	2	30,875.5	36.4
Нийт дүн	6	36,065.9	4	5,190.4	2	30,875.5	36.4

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 104,966.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 76,029.7 мянган төгрөгийн алдааг залруулж, шилэн дансанд мэдээлээгүй 5,000.0 төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 23,936.4 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

#### Залруулсан алдаа

Аудитаар үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглах шинж чанартай үндсэн хөрөнгийн шинэчлэн тогтоосон үнийн дүнг санхүүгийн тайланд тусгахдаа дахин үнэлгээний дансыг нэмэгдүүлснийг УСНББОУС 23 "Арилжааны бус орлого" гэсэн стандартын 42,43 дүгээр параграфын дагуу орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэх нь зүйтэй гэсний дагуу залруулга хийж санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Тайлант онд үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах, үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай 598 дугаар тогтоолоор үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглах 231 ширхэг 195,482.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг 76,029.7 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосныг санхүүгийн тайланд тусгахдаа дахин үнэлгээний дансыг нэмэгдүүлсэн байна.

#### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар шилэн дансанд мэдээлээгүй 5,000.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

1. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл шилэн дансны мэдээлэл 5.5, шилэн дансны цахим хуудасны энэ хууийн 3.3-т заасан ангилалыг баримталсан байх бөгөөд мэдээллийг бүрэн тусгасан байна; заалтуудтай нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.
2. Шийдвэрлэсэн нь:
3. Албан шаардлага

## **Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн 23,936.4 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### **3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

Ерөнхий боловсролын Шинэ эрин сургууль нь Баянгол дүүргийн Ган зам 20 дугаар сургуулийн хашаанд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 3,750,560.3 мянган төгрөгийн өртөг бүхий 640 суудалтай хичээлийн байр 2009 онд хүлээн авч данс бүртгэлд тусгасан боловч өөрийн хичээлийн байранд ногдох газрын гэрчилгээг одоог хүртэл аваагүй байна. Иймд БШУЯ-нд шууд харьяалагддаг олон улсын хөтөлбөртэй тус сургуульд тулгарч байгаа газартай холбоотой асуудал нь тухайн сургууль бие даан шийдэх боломжгүй тул ТЕЗ-ийн аудитад асуудлыг үргэлжлүүлэн авч үзэх нь зүйтэй гэж санал оруулж байна.

#### **Менежментийн захидал**

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **1. Зардлын данстай холбоотой асуудал**

##### **1.1 Илрүүлэлт:**

Зардлын анхан шатны и-баримтын нийт 90,458.2 мянган төгрөгийн, 67 аж ахуйн нэгж, хувь хүмүүсээс авсан худалдан авалтыг тулган шалгахад 17 аж ахуйн нэгжүүд 23,936.4 мянган төгрөгийн борлуулалтаа НӨАТ-ын төлбөрийн цахим системд худалдан авалтаар бүртгээгүй, цахим төлбөрийн баримтгүй байна.

Энэ нь үнэлгээ, үнэн зөв байдал, хэмжилт, иж бүрэн байх, тохиолдсон байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 5 “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм” гэсэн заалтын дагуу төлбөрийн баримтгүй ажил гүйлгээ хийхгүй байх, харилцагч байгууллагаас бүрэн гаргуулан авахад хяналт тавьж ажиллах гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

##### **1.2 Эрсдэл:**

*Анхан шатны баримтын бүрдэлгүйгээр ажил гүйлгээ бүртгэж, тайлагнасан байх.*

##### **1.3 Өгсөн зөвлөмж:**

Худалдан авалт хийхдээ хууль тогтоомж, журмын дагуу татварын цахим системд и-баримтыг харилцагч байгууллагуудаар бүрдлийг хангуулж ажиллах.

##### **1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

*И-баримтын шивэлтийг сар бүр шалгаж ажиллана.*

## 2.Цалин, нэмэгдэл хөлс олголтын талаар

### 2.1 Илрүүлэлт:

Тайлант онд сургуулийн захирлын 2020 оны 12 дугаар сарын 21 -ний өдрийн А/34 дүгээр тушаалаар үр дүнгийн урамшуулал олгохдоо Засгийн газрын 2013 оны 393 дугаар тогтоол, хүчингүй болсон хуулийн заалтыг мөдрлөг болгосон мөн 4 дүгээр улиралд 2 удаа үр дүнгийн урамшуулал олгож Засгийн газрын 2019 оны 5 дугаар тушаалаар батлагдсан төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 3 хавсралтын 4 дүгээр заалтын 4.4-ын сар бүр тооцож, улирал бүр олгоно гэснийг мөрдөж ажиллаагүй байна.

Энэ нь эрх ба үүрэг, оршин байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Засгийн газрын 2019 оны 5 дугаар тушаалаар батлагдсан төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 3 хавсралтын 4 дүгээр заалтын 4.4-д Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн багш, туслах багшийн сургалтын арга зүй, хэрэглэгдэхүүн боловсруулах, цахим сан бүрдүүлэх, уралдаан тэмцээнд хүүхдүүдийг бэлтгэх, жижүүр багшаар ажиллах, эцэг эх, асран хамгаалагчтай харилцах зэрэг ажлыг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн дэвтэр засах, давтлага өгөх, шалгалт, шүүлэг авах, сургалтын арга зүй, технологи, инновацыг хөгжүүлэх, цахим болон интерактив, нээлттэй контент, хэрэглэгдэхүүн боловсруулах, сурагчдын цахим сан бүрдүүлэх, секц дугуйлан хичээллүүлэх, олимпиад, уралдаан тэмцээнд сурагчдыг бэлтгэх, жижүүр багшаар ажиллах, эцэг эх, асран хамгаалагчтай харилцах зэрэг ажлыг тус тус үнэлж албан тушаалын сарын үндсэн цалингийн 20 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг сар бүр тооцож, улирал бүр олгоно гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

### 2.2 Эрсдэл:

*Санхүүгийн тайлан, тодруулгууд буруу илэрхийлэгдэх;*

### 2.3 Өгсөн зөвлөмж

Багш ажилтнуудын ажлын үр дүнг сар бүр тооцож, үр дүнгийн урамшууллыг улирал бүр олгож байх;

### 2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хүлээн зөвшөөрч цаашид үр дүнгийн урамшууллыг улирлын урамшуулалтай давхцуулахгүй байхаар ажлын үнэлгээг хийж зохион байгуулалтандаа анхаарч ажиллана.

## 3.Хөрөнгө, материалын тооллого, тооцоо

### 3.1 Илрүүлэлт:

Эд хөрөнгийн жилийн эцсийн тооллогын комиссын тушаалаар ахлагчаар нягтлан бодогч Б.Дэлгэрцэцэг, гишүүдийн бүрэлдэхүүнд нярав М.Мөнхбаяр нарыг томилон үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогыг хийсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн Тооллогын комисс, түүний эрх, үүрэг 72.1-д Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь тооллого эхлэхээс өмнө өмч хамгаалалтад хяналт тавих үүрэг бүхий болон холбогдох

мэргэжлийн хүмүүсийг оролцуулан Тооллогын комисс томилж байгуулна гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

### 3.2 Эрсдэл:

*Хөрөнгө, материалын тооллого тооцоо үнэн зөв илэрхийлэгдэхгүй байх;*

### 3.3 Өгсөн зөвлөмж

Тооллого эхлэхээс өмнө өмч хамгаалалтад хяналт тавих үүрэг бүхий болон холбогдох мэргэжлийн хүмүүсийг оролцуулан тооллогын комиссын ахлагчийг өмч хамгаалах зөвлөлийн гишүүдээс томилж хөрөнгө , бараа материалын тооллогыг хийж байх.

### 3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хүлээн зөвшөөрч цаашдын ажлын зохион байгуулалтандаа анхаарч ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2021 он	Аудитын нэр: Шалгагдсан байгууллагын нэр	<b>Ерөнхий боловсролын Шинэ эрин сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</b>	Аудитын код: САГ-2021/77/СТА-ТШЗ
		<b>Ерөнхий боловсролын Шинэ эрин сургууль</b>	Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Тайлант онд 67 аж ахуйн нэгжтэй хийсэн 90,458.2 мянган төгрөгийн худалдан авалтыг и-баримттай тулган шалгахад 17 аж ахуйн нэгжүүд 23,936.4 мянган төгрөгийн борлуулалтаа НӨАТ-ын төлбөрийн цахим системд яамны худалдан авалтаар бүртгээгүй, цахим төлбөрийн баримтгүй байна.	23,936.4	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	Б.Амартүвшин Б.Дэлгэрцэцэг
2	Тайлант хугацаанд оруулбал зохих 173 мэдээллээс хугацаандаа оруулсан 167 мэдээлэл, хугацаа хоцроосон 5 мэдээлэл байршуулж, 1 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.	5,000.0	Албан шаардлага	Нягтлан бодогч	Д.Дэлгэрцэцэг
3	Тайлант онд сургуулийн захирлын 2020 оны 12 дугаар сарын 21 -ний өдрийн А/34 дүгээр тушаалаар үр дүнгийн урамшуулал олгохдоо Засгийн газрын 2013 оны 393 дугаар тогтоол, хүчингүй болсон хуулийн заалтыг мөдрлөгөө болгосон мөн 4 дүгээр улиралд 2 удаа үр дүнгийн урамшуулал олгож Засгийн газрын 2019 оны 5 дугаар тушаалаар батлагдсан төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 3 хавсралтын 4 дүгээр заалтын 4.4-ын сар бүр тооцож, улирал бүр олгоно гэснийг мөрдөж ажиллаагүй байна.	0	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	Б.Амартүвшин Б.Дэлгэрцэцэг
4	Эд хөрөнгийн жилийн эцсийн тооллогын комиссын тушаалаар ахлагчаар нягтлан бодогч Б.Дэлгэрцэцэг, гишүүдийн бүрэлдэхүүнд нярав М.Мөнхбаяр нарыг томилон үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогыг хийсэн байна..	0	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	Б.Амартүвшин Б.Дэлгэрцэцэг
<b>ДҮН</b>		<b>28,936.4</b>			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 28/А0160058

Улаанбаатар хот

САГ-2021/77/СТА-ТЧЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Ерөнхий боловсролын Шинэ эрин сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд байгууллагын шилэн дансны цахим хуудаст байршуулах 173 мэдээллээс хугацаа хоцроосон 5 мэдээлэл, мөн 1 мэдээллийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:”, 6.4.5 “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д заасныг үндэслэн ШААРДАХ нь:

1. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж мэдээллийг ил тод, цаг хугацаанд нь бүрэн байршуулж, биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ерөнхий боловсролын Шинэ эрин сургуулийн захирал Б.Амартүвшин, нягтлан бодогч Б.Дэлгэрцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АХЛАХ АУДИТОР

Б.СЭРЖМЯДАГ

ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ:  
БАЯН ТАШААГИЙН ЭХ АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ

Т.ХОРОЛСҮРЭН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2021\0225auditin 2-R Gazar 25.Docx

001081102